

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
№2023/22 тоот тогтоолын Хавсралт 1



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (цаашид хороо гэх)-ны бүрэлдэхүүн, гишүүдийн бүрэн эрх, зохион байгуулалтын хэлбэр, бүрэн эрх зэрэг хорооны үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, зөвлөмж, дүгнэлт гарган Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) -д танилцуулна.

ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- 2.1 Хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэнэ.
- 2.2 Хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх ба хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно.
- 2.3 Аудитын хорооны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн турван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна.
- 2.4 Хорооны дарга, гишүүд нь санхүү, эдийн засаг, нягтлан бодож бүртгэлийн чиглэлээр мэдлэг, боловсрол, дадлага туршлагатай байна.
- 2.5 Хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.
- 2.6 ТУЗ нь хорооны гишүүдийг хугацаанаас нь өмнө чөлөөлж, бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох эрхтэй.
- 2.7 ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга нь Хорооны нарийн бичгийн даргын ажлыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ХОРООНЫ ХУРАЛ

- 3.1 Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хурал байна.
- 3.2 Хуралд хорооны гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 3.3 Хуралд оролцох боломжгүй гишүүд урьдчилан бичгээр саналаа өгөх боломжтой ба гишүүдийн саналыг хурлын ирц бүрдэлт болон санал хураалтын дунд оруулж тооцно.
- 3.4 Хорооны хурлын хуваарь болон хурлаар хэлэлцэх асуудлыг ТУЗ болон Хорооноос тухай бүр батална.
- 3.5 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дэргэдэх дотоод аудитор болон хөндлөнгийн аудитын компанийн саналаар хурлыг зарлан хуралдуулж болно.
- 3.6 Хорооны хуралд ТУЗ-ийн бусад гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх аудитор, Гүйцэтгэх захирал болон хорооны шаардлагатай гэж үзсэн бусад этгээд оролцож болно.
- 3.7 Хурлаар хэлэлцэх асуудлуудын холбогдох материалыг 3-аас доошгүй хоногийн дотор хүргүүлэх, гишүүд урьдчилан танилцсан байна.
- 3.8 Хороо тодорхой асуудал хэлэлцэж санал, дүгнэлт, зөвлөмжийг бичгээр үйлдэж, ТУЗ-д танилцуулна.

ДӨРӨВ. ХОРООНЫ БҮРЭН ЭРХ

- 4.1 Хороо нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангаж, ТУЗ, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 4.2 Хороо нь дараах эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

- 4.2.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналт, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- 4.2.2 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайланда шинжилгээ, үнэлгээ, хийлгэсэн аудитын үр дүнгийн талаар зөвлөмж өгөх, ТУЗ-д танилцуулах;
- 4.2.3 Компанийн дотоод хяналтад хяналт тавих, сайжруулах талаар зөвлөмж өгөх;
- 4.2.4 Аудитын байгууллагыг судлан сонгон шалгаруулалт хийн хөндлөнгийн аудитыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, санал боловсруулах;
- 4.2.5 Хөндлөнгийн аудитыг томилох, гэрээг цуцлах саналыг ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэх;
- 4.2.6 Хөндлөнгийн аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл тодорхойлж, түүнийг удирдах;
- 4.2.7 Хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах;
- 4.2.8 Аудитын тайланг хянан үзэх, компанийн дотоод хяналтын төлөвлөгөөнд заавар зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд хэсэгчилсэн аудитыг санаачлан хийлгэх;
- 4.2.9 Компанийн дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэл, тайлагнал, хөндлөнгийн аудитын талаар ирсэн санал, гомдлыг хүлээн авах хянан үзэх;
- 4.2.10 ТУЗ болон хорооны хэлэлцэх шаардлагатай гэсэн аливаа асуудлаар уулзалт хийх;
- 4.2.11 Хууль тогтоомжид заасан, ТУЗ-өөс тодорхойлсон бусад асуудлаар дүгнэлт гаргах.

ТАВ. БУСАД

- 5.1 Хорооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ баталж, хэрэгжилтийн тайланг танилцуулна.
- 5.2 Энэхүү журмыг баталсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандaa мөрдөх бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
2023 ОН